



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 4/01

Модот

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2024 оны А/675 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06- ноос 2025 оны 01 дүгээр сарын 20-ны хооронд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Цэргийн тоо бүртгэл дээр сууж бүртгэл хөтлөх судалгаа гаргах хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Шинэчилсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ү.Ичинхорлоо	- Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	У.Гантулга	- I Багийн Засаг дарга
	Б.Чулуунцэцэг	- II Багийн Засаг дарга
	Д.Мягмарсүрэн	- III Багийн Засаг дарга
	О.Тунгалагмөрөн	- IV багийн засаг дарга

4. Дээр дурьдсан хугацаанд цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ судалгааг холбогдох маягтын дагуу гаргаж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 02 ны өдрийн
01 дүгээр захирамжийн
хавсралт

Цэргийн бүртгэл дээр суух хуваарь, гаргаж өгөх судалгааны хуваарь

д/д	Албан тушаал	Нэрс	Өдөр	гаргаж өгөх судалгаа
1	ЗДТГазрын дара	Ү.Ичинхорлоо	1/20	Нэгтгэл гаргах, тушаах
2	IY Багийн Засаг дарга	О.Тунгалагмөрөн	1/06	Цэргийн 1-р зэргийн бэлтгэл үүрэгтний мэдээ, судалгаа гаргах
3	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын Улсын байцаагч	Д.Өсөхгэрэл	1/07	Ердийн хөсөг, тоног хэрэгслийн мэдээ, Агт морьдын мэдээ
4	Санхүү албаны нягтлан бодогч	Б.Буяндэлгэр	1/08	Цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний тоон бүртгэлийн дүнг 2024 оны жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаа
5	Татварын байцаагч	П.Ганцэцэг	1/09	Авто машин, зам барилгын техник, трактор, чиргүүл, мотоциклийн жагсаалт, Ангийн бууны нэгдсэн мэдээ
6	I БЗДарга	У.Гантулга	1/10	Ахмад дайчид, бэлтгэл офицерын бүртгэл,
7	Төрийн сан, төлбөр тооцооны мэргэжилтэн	О.Батбаяр	1/13	Эрчүүдийн судалгаа бүртгэл, Тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй хүмүүсийн бүртгэл
8	Улсын бүртгэгч	З.Энхбямба	1/14	Цэргийн өмнөх насны бүртгэл (16-17) нас, нэгдсэн мэдээ гаргах гаргах
9	БОХУБайцаагч	С.Энхбаяр	1/15	Цэргийн 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний нэрсийн жагсаалт / 25-50 нас/
10	НБТүшмэл	И.Найманцэцэг	1/16	Орон нутагт байгаа офицер ахлагч, цэргийн албан хаагч
11	ХААТасгийн мэргэжилтэн	Ш.Оюунчимэг	1/17	51-60 насны цэргийн алба хаасан болон хаагаагүй нөөц эрчүүдийн бүртгэл
12	Байгаль хамгаалагч	Ж.Тодбилэг	1/23	19-45 насны тусгай мэргэжилийн эмэгтэйчүүдийн бүртгэл, Бэлтгэл байлдагч, түрүүчийн тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ
13	СА-ны дарга	Г.Болор - Эрдэнэ	1/20	1-р зэргийн бэлтгэл үүрэгтний нэгдсэн мэдээ гаргах
14	III БЗДарга	Д.Мягмарсүрэн	1/20	Цэргийн 2-р зэргийн бэлтгэл үүрэгтний нэрсийн жагсаалт / 18-25 нас /
15	Мэдээллийн ажилтан	Л.Номин-Эрдэнэ	Өдөр бүр	E-Mongolia гар утасны аппликейшн болон системээр нэвтрэх, www.e-mongolia.mn сайтаар иргэдийг бүртгүүлэх, зөвлөгөө өгөх
16	ЗДТГ-ын нярав	С.Ган-Очир	1/21	Баримт үдэх

Жич: Судалгааг гаргахдаа нэгтгэл мэдээг хамтад нь гаргаж өгнө.